

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны... сарын ....-ний өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

**1 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:**

	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Аймаг, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүх	Жаргалант сум /Ховд аймаг/	Ховд, Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүх	Улаангом /Увс аймаг/	Увс, Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх	Мөрөн сум /Хөвсгөл аймаг/	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүх	Баянхонгор /Баянхонгор аймаг/	Баянхонгор, Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны 5	Хар-Хорин сум /Өвөрхангай аймаг/	Архангай, Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

	дугаар шүүх	тойргийн		
6	Эрүү, хэргийн заалдах дугаар шүүх	Иргэний давж шатны 6 тойргийн	Булган сум /Булган аймаг/	Булган, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Эрүү, хэргийн заалдах дугаар давж шатны шүүх	Иргэний давж шатны 7 тойргийн	Дархан сум /Дархан-Уул аймаг/	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Эрүү, хэргийн заалдах дугаар шүүх	Иргэний давж шатны 8 тойргийн	Чингис /Хэнтий аймаг/	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Эрүү, хэргийн заалдах дүгээр шүүх	Иргэний давж шатны 19 тойргийн	Сайншанд сум /Дорноговь аймаг/	Дорноговь, Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Эрүү, хэргийн заалдах дүгээр шүүх	Иргэний давж шатны 10 тойргийн	Даланзадгад сум /Өмнөговь аймаг/	Дундговь, Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Эрүүгийн давж шатны 11 дүгээр шүүх	хэргийн тойргийн	Зуунмод /Төв аймаг/	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Иргэний давж шатны 12 дугаар шүүх	хэргийн тойргийн	Улаанбаатар	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Хоёр.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх				
1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх		Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

**2 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:**

	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
2	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг
Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх			
1	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
2	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг
Гурав. Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх	Налайх /Улаанбаатар хот/	Нийслэлийн Налайх, Багахангай, Багануур дүүрэг
Дөрөв. Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх			
1	Дөрөв. Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Тав. Захиргааны хэргийн анхан шатны шүүх			

1	Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр тойргийн шүүх	Өлгий сум /Баян-Өлгий аймаг/	Ховд, Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар тойргийн шүүх	Улиастай сум /Завхан аймаг/	Увс, Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар тойргийн шүүх	Есөнбулаг сум /Говь-Алтай аймаг/	Баянхонгор, Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр тойргийн шүүх	Булган сум /Хөвсгөл аймаг/	Хөвсгөл, Булган, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар тойргийн шүүх	Хар-Хорин сум /Өвөрхангай аймаг/	Архангай, Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар тойргийн шүүх	Дархан сум /Дархан-Уул аймаг/	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар тойргийн шүүх	Чойбалсан /Дорнод аймаг/	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар тойргийн шүүх	Сайншанд сум /Дорноговь аймаг/	Дорноговь, Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар тойргийн шүүх	Сайнцагаан сум /Дундговь аймаг/	Дундговь, Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр тойргийн шүүх	Улаанбаатар Зуунмод	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Зургаа.Сум дундын анхан шатны шүүх			
1	Сум дундын анхан шатны 1 дүгээр шүүх	Эрдэнэбулган сум /Архангай аймаг/	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2	Сум дундын анхан шатны 2 дугаар шүүх	Өлгий сум /Баян-Өлгий аймаг/	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Сум дундын анхан шатны 3 дугаар шүүх	Баянхонгор сум /Баянхонгор аймаг/	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Сум дундын анхан шатны 4 дүгээр шүүх	Булган сум /Булган аймаг/	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Сум дундын анхан шатны 5 дугаар шүүх	Есөнбулаг сум /Говь-Алтай аймаг/	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Сум дундын анхан шатны 6 дугаар шүүх	Чойр сум /Говьсүмбэр аймаг/	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Сум дундын анхан шатны 7 дугаар шүүх	Дархан сум /Дархан-Уул аймаг/	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Сум дундын анхан шатны 8 дугаар шүүх	Сайншанд сум /Дорноговь аймаг/	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Сум дундын анхан шатны 9 дүгээр шүүх	Замын-Үүд сум /Дорноговь аймаг/	Дорноговь аймгийн Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд сумд
10	Сум дундын анхан шатны 10 дугаар шүүх	Чойбалсан сум /Дорнод аймаг/	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Сум дундын анхан шатны 11 дүгээр шүүх	Сайнцагаан сум /Дундговь аймаг/	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Сум дундын анхан шатны 12 дугаар шүүх	Улиастай сум /Завхан аймаг/	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд

13	Сум дундын анхан шатны 13 дугаар шүүх	Тосонцэнгэл сум /Завхан аймаг/	Завхан аймгийн Тэс, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Их-Уул, Тосонцэнгэл сумд
14	Сум дундын анхан шатны 14 дүгээр шүүх	Баян-Өндөр сум /Орхон аймаг/	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Сум дундын анхан шатны 15 дугаар шүүх	Даланзадгад сум /Өмнөговь аймаг/	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
16	Сум дундын анхан шатны 16 дугаар шүүх	Ханбогд сум /Өмнөговь аймаг/	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Цогтцэций, Ханбогд сумд
17	Сум дундын анхан шатны 17 дугаар шүүх	Арвайхээр сум /Өвөрхангай аймаг/	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
18	Сум дундын анхан шатны 18 дугаар шүүх	Хархорин сум /Өвөрхангай аймаг/	Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Есөнзүйл, Өлзийт, Бүрд, Баян-Өндөр сумд
19	Сум дундын анхан шатны 19 дүгээр шүүх	Баруун-Урт сум /Сүхбаатар аймаг/	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Сум дундын анхан шатны 20 дугаар шүүх	Сүхбаатар сум /Сэлэнгэ аймаг/	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
21	Сум дундын анхан шатны 21 дүгээр шүүх	Мандал сум /Сэлэнгэ аймаг/	Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумд
22	Сум дундын анхан шатны 22 дугаар шүүх	Сайхан сум /Сэлэнгэ аймаг/	Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Сайхан сумд

23	Сум дундын анхан шатны 23 дугаар шүүх	Зуунмод сум /Төв аймаг/	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
24	Сум дундын анхан шатны 24 дүгээр шүүх	Улаангом сум /Увс аймаг/	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
25	Сум дундын анхан шатны 25 дугаар шүүх	Жаргалант сум /Ховд аймаг/	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
26	Сум дундын анхан шатны 26 дугаар шүүх	Булган сум /Ховд аймаг/	Ховд аймгийн Булган, Алтай, Үенч, Цэцэг, Мөст сумд
27	Сум дундын анхан шатны 27 дугаар шүүх	Мөрөн сум /Хөвсгөл аймаг/	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
28	Сум дундын анхан шатны 28 дугаар шүүх	Чингис сум /Хэнтий аймаг/	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн, Цэнхэрмандал сумд
29	Сум дундын анхан шатны 29 дүгээр шүүх	Бор-Өндөр сум /Хэнтий аймаг/	Хэнтий аймгийн Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумд

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---оОо---

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД



Х.НЯМБААТАР

## ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж;

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталж, уг хуваарийн 3.3.1-д “шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлэх чиглэлийг баримтлан Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулах” гэж;

“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүх тогтолцоог төлөвшүүлэх” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 64-т “иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх зорилгоор тойргийн зарчмаар ажиллуулах боломжийг боловсронгуй болгох үүднээс Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулах” гэж тус тус заасан.



Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхтэй зөвшилцөж Шүүх байгуулах тухай хуулийн төслийн саналыг ирүүлсэн.

## **1.2. Практик шаардлага**

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар анхан болон давж заалдах шатны 116 шүүхийг засаг захиргааны нэгжүүдэд байршихаар байгуулсан нь байршлын хувьд шүүхийн үйлчилгээ иргэнд ойр, шүүхэд хандах иргэний эрхийн баталгаа хангагдсан гэж үзэж болох ч шүүхийн байршлыг өөрчлөх, шүүхийн үйлчилгээг илүү сайжруулах, чанаржуулах дараах практик хэрэгцээ, шаардлага байна.<sup>1</sup>

Орон нутаг дахь 19 аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоо ажлын бодит ачаалалд үндэслээгүй, ажлын ачаалал тэнцвэртэй бус, зарим шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцээгүй, зарим шүүхэд хэргийг санамсаргүй тохиолдлоор хуваарилах зарчим хэрэгжих боломжгүй болох, хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдахгүй байх зэрэг сөрөг үр дагавар гарч байгаа нь иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхэд сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

Нийслэл болон аймаг дахь анхан шат, давж заалдах шатны шүүхийн ажлын ачаалал тэнцвэртэй бус, зарим шүүх хэт их ачаалалтай, зарим шүүхийн ачаалал хэт бага байгаа нь шүүх хуралдаан хойшлох, шүүхийн шийдвэрийг албажуулах, гардуулах хугацааг хэтрүүлэх үндсэн нөхцөл болж шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг алдагдуулснаар шүүхийн үйлчилгээний чанарт сөрөг нөлөөллийг үзүүлж, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулах гол хүчин зүйл болж байна.

2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар засаг захиргааны нэгж бүрд шүүхийг байршуулснаар зарим шүүхэд шүүх бүрэлдэхүүн дутагдалтайгаас шалтгаалан эрүүгийн хэргийг өөр шүүхэд шилжүүлэх, дээд шатны шүүхээс бүрэлдэхүүнд орох шүүгчийг томилох, иргэний болон захиргааны хэргийн хувьд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж тухайн шүүхийн Ерөнхий шүүгч өөр шүүхийн шүүгчийг бүрэлдэхүүнд томилох шаардлага гарч байгаа нь дээд шатны шүүхээс хэрэгт нөлөөлж бүрэлдэхүүн томилогдсон байх хардлагыг хэргийн оролцогчдод төрүүлэх зэргээр шүүхэд итгэх иргэдийн итгэлийг буурахад нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэж байна. Үүнтэй холбоотойгоор шүүх бүрэлдэхүүнд орохоор томилогдсон шүүгчийн өөр шүүхэд томилолтоор ажиллах үеийн аюулгүй байдалд эрсдэл учрах, хэргийн материалтай танилцах хугацаа хангалтгүй байдгаас шүүхийн шийдвэрийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Тухайлбал, энэхүү бүрэлдэхүүн томилох, томилолтоор ажиллах асуудал 2019-2021 онд давхардсан тоогоор 2156 удаа шүүгч, 1904 удаа шүүхийн захиргааны ажилтан өөр шүүхэд томилолтоор очиж ажилласан байх бөгөөд томилолт, шатахууны зардалд нийтдээ 427.4 сая төгрөг зарцуулжээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүх өөрийн байртай байх, шүүхийн байранд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс өөр үйл ажиллагаа явуулахыг хориглохоор заасан хэдий ч засаг захиргааны нэгж бүрд байгуулсан шүүхүүд өөрийн

---

<sup>1</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний 170 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1123 тоот албан бичгээр ирүүлсэн санал

байргүй, түрээсийн байранд болон бусад төрийн байгууллагатай нэг дор үйл ажиллагаа явуулдаг, доод шатны шүүхийн шийдвэрийг хянах дээд шатны шүүх нь нэг байранд үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь шүүн таслах ажиллагааны онцлогт нийцсэн шүүхийн стандартын барилга байхгүй, шүүх хуралдааны танхимын хүрэлцээ, багтаамж дутагдалтай нөхцөл байдалд хүргэснээр шүүх хуралдаан хойшлох шалтгаануулын нэг болж, улмаар шүүн таслах ажиллагаа сунжрах, шүүхээр үйлчлүүлэгч иргэд санхүү, цаг хугацааны нэмэлт зардал, чирэгдэл гаргахад хүргэж байна.

Өнгөрсөн 2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оролцуулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн.

Энэ хугацаанд шүүхийн зарим үйл ажиллагааг цахимаар явуулж байсан туршлагад тулгуурлан цахим үндэстэн болох Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-тай уялдуулж шүүхийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, иргэдийн цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр шүүхэд хандах эрхийг хангах, шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлж, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах, үүнтэй холбогдуулан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, шүүхийн төсөв, нөөцийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Давж заалдах шатны шүүхийн тухайд хэргийн оролцогч давж заалдах гомдлыг анхан шатны шүүхээр дамжуулан гаргадаг, давж заалдах шатны шүүх хуралдааныг хэргийн оролцогчийг заавал байлцуулахгүйгээр шийдвэрлэдэг процесс хуулийн зохицуулалт, давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй нотлох баримтыг хэлэлцдэггүй, хэргийг хавтаст хэрэг цугласан баримтын хүрээнд хянадаг, улсын хэмжээнд нийт эрүүгийн хэргийн 18 орчим хувь, иргэний хэргийн 6 орчим хувь нь давж заалдсан сүүлийн 5 жилийн статистик тоо, давж заалдах шатны шүүх хуралдааны 50 орчим хувийг цахим шүүх хуралдаан эзэлж байгаа судалгааны дүн, нийслэл дэх давж заалдах шатны шүүхийн болон орон нутаг дахь шүүхийн ачааллын эрс ялгаатай байдал, шүүх бүрэлдэхүүний хүрэлцээ зэргийг харгалзаж өөрчлөн зохион байгуулах шаардлагатай байна.

Аймаг дахь эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн тухайд одоо үйлчилж байгаа тогтолцоогоор засаг захиргааны үндсэн нэгжид анхан шатны шүүхүүдийг байгуулснаар иргэнд ногдох шүүхийн хүртээмж хэвийн байгаа хэдий ч эрүү, иргэний хэргийн шүүхүүдийг дагнаж байгуулсан нь шүүхийн нөөцийг сарниаж, анхан шатны зарим шүүхүүд 1-2 шүүгчтэй ажиллаж байгаа нь иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, шүүхийн төсөв, шүүгчдийн хараат бус болон аюулгүй, бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна.

Шүүгчийг татгалзах, хэргийг шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг санамсаргүй сонгох, хэргийг шийдвэрлэх шүүгч давхцахгүй байх зэрэг иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх хэрэгжих баталгаа болсон зарчмууд биелэхэд анхан шатны шүүхийн орон нутаг дахь тогтолцоо хүндрэл учруулж байна.

Адил шатны шүүхээс сум, заримдаа аймаг алгасан шүүх бүрэлдэхүүнийг томилуулж байгаа нь шүүхийн төсөв, шүүгчийн аюулгүй байдалд эрсдэл, хохирол учруулсаар байна.

Иймээс орон нутаг буюу 21 аймаг дахь анхан шатны эрүү, иргэний шүүхүүдийг нэгтгэж, шүүхийн ажил үүргийн хуваарь, орон тоог оновчтой тогтоох замаар шүүхийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тухайд нийслэлээс бусад 21 аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал илт бага байгаа талаар судалгаа гарсан байна.<sup>2</sup> Уг судалгаанд “2020 оны байдлаар Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд захиргааны 52.5 хэрэг хянан шийдвэрлэсэн байхад бүх аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч дунджаар 11.2 хэрэг шийдвэрлэсэн нь даруй тав дахин бага ачаалалтай байгаа нь ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна. Нийслэлээс бусад орон нутаг дахь бүх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн жилд шийдвэрлэж буй хэргийн тоо байвал зохих хэмжээний 22 хувьд л хүрч байна. Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгууд дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчид ногдох хэрэг дунджаар 10 хүрэхгүй байгаа нь байвал зохих ачааллаас 80 орчим хувиар бага байна.” гэж дүгнэсэн байдаг. Түүнчлэн аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны бүх шүүхийн шийдвэрлэсэн хэргийн 2020-2022 оны байдлаарх тоон статистикаас<sup>3</sup> харахад хэргийн тоо зарим аймагт өссөн үзүүлэлттэй байх хэдий ч жилд 1 шүүгчид ногдох зохих ачаалалд хүрэхээргүй байна.

Олон улсын түвшинд шүүхийн үйлчилгээний хүртээмжийг засаг захиргааны нэгж бүрд шүүх байршуулснаар бус харин шүүгчийн орон тооны хүрэлцээтэй байдал, иргэний шүүхэд хандах эрхийг хангах эрх зүйн орчин, шүүхийн үйлчилгээний мэдээллийг иргэдэд хүргэх үр өгөөжтэй механизм, иргэдийн төрөөс эрх зүйн туслалцаа авах боломж, шүүхийн өмнөх маргаан шийдвэрлэх ажиллагааг бүрдүүлсэн байдал, цахим технологийн дэвшлийг ашиглан иргэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран шүүхэд хандах боломжийг бүрдүүлсэн байдлаар ойлгож байгааг харгалзах шаардлагатай байна.

Түүнчлэн дэлхийн ихэнх оронд дагнасан шүүх гэх ойлголтыг шүүхийг дагнан байгуулах, танхимын зохион байгуулалтаар байгуулах, дагнасан буюу мэргэшсэн шүүгчийг томилох гэх загварт хуваан авч үзэж байгаа бөгөөд дагнасан хэлбэрээр танхим байгуулах асуудлыг шүүхийн захиргаа, хүний нөөц, төсвийн хувьд хэмнэлттэй, шүүхийн тогтолцооны хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг байна. Иймд шүүх бүтэц, зохион байгуулалтын хувьд нэг шүүхийн зохион байгуулалтад орох нь дагнасан шүүхийн тогтолцооноос ухарч буй хэлбэр биш бөгөөд ийнхүү эрүү, иргэний хэргийн зэрэг танхимын зохион байгуулалтад оруулж, танхимын бүрэлдэхүүн өөр өөрсдийн харьяалах танхимын хэрэг маргааныг шийдэх нь мөн л ялгаагүй шүүгчийг дагнан мэргэшүүлэх нэг хэлбэр гэдгийг харгалзах шаардлагатай байна.

*Хялбар ажиллагааны төрлөөр шүүх байгуулах талаар:*

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл болон Нэгдсэн Үндэсний байгууллагын Дур зоргоор баривчлан саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлтэд сэжигтнийг баривчлах ажиллагаа шүүхийн зөвшөөрөлгүй явагддаг, шүүхийн хяналтад бүрэн ороогүй байгаатай холбогдуулан сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг нэг мөр хэрэгжүүлэх байдлаар шүүхийн хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байгаа талаар дурджээ.

<sup>2</sup> Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгээс хийсэн “Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх” бодлогын судалгаа 2021 он;

<sup>3</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон статистик мэдээлэл



Энэ асуудалтай холбогдуулан хууль сахиулах байгууллагаас шүүхийн байгууллагад хандан ажлын цаг дууссаны дараа, амралтын болон бүх нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд баривчлах ажиллагаа хийгддэгтэй холбогдуулан 24 цагийн шүүх, жижүүрийн шүүх аижллуулах хэрэгцээ шаардлага байгаа талаар санал, хүсэлт их гаргаж байна.

Түүнчлэн сүүлийн 3 жилийн шүүн таслах жаиллагааны статистик дүн мэдээгээс үзэхэд 2020-2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 35.3 хувийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн нийт 14016 хэргийн 49.6 хувь буюу 6949 хэргийг нийслэлд, 50.4 хувь буюу 7067 хэргийг орон нутагт тус тус хянан шийдвэрлэжээ.

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017-2021 онд дунджаар хүлээн авсан нэхэмжлэлийн 46.7 хувийг бага үнэ /10 саяаас хэтрэхгүй/-ийн дүнтэй нэхэмжлэл эзэлсэн байна. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчийн хүлээн авсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо дүүрэг бүрд харилцан адилгүй байгаа боловч жилд дунджаар 136 нэхэмжлэл хүлээн авсныг зохист ачаалал гэж судалгаагаар дүгнэжээ. Мөн судалгаагаар хийсэн өгөгдөлд үндэслэн нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах, энэ төрлийн нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гарагх нь нийт хэргийг шийдвэрлэх ачааллаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгоно гэж дүгнэсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан мөрдөн шалгах ажиллагаан дахь шүүхийн хяналтыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай процессоор хэрэгждэг тодорхой ажиллагаануудыг болон бага үнийн дүнтэй иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх хялбар ажиллагааны төрлөөр дагнасан шүүхийг нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулах шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхтэй зөвшилцөн ирүүлсэн саналыг харгалзан Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал, байрших газар, зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатны шүүх байгуулахад оршино.

Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, төвлөрлийг сааруулах, шүүхийн хөрөнгө оруулалт, барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх бодлого зэрэгтэй уялдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо, иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг дордуулахгүй байх, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх зарчим, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 58 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлт зэргийг баримтална.

Дээрх шалгууруудыг харгалзан Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд давж заалдах болон анхан шатны шүүхийг дараах байдлаар байгуулахаар тусгана. Үүнд:

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг өөрчлөн байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тусгана.

Ингэхдээ Монгол Улсын хэмжээнд байгаа эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 25 шүүхийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар нэгтгэн зохион байгуулж, 12 шүүх болгон өөрчлөн байгуулах бөгөөд эдгээр давж заалдах шатны шүүх дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан, танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын шүүхийн тухай хуулиар нээлттэй байна.

Харин захиргааны хэргийн давж заалдах шатны дагнасан шүүхийн одоогийн тогтолцоог хэвээр хадгална.

Ингэснээр одоо байгаа давж заалдах шатны нийт 26 шүүхийг 13 шүүх болгон өөрчлөн байгуулна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд анхан шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тусгана.

#### *2.1.Дүүргийн анхан шатны шүүх:*

Одоо байгаа дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 9, Эрүүгийн хэргийн анхан шатны 9, нийт 18 шүүхийн зохион байгуулалтыг өөрчлөн байгуулна.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар зохион байгуулж, иргэний хэргийн 2, эрүүгийн хэргийн 2 буюу нийт 4 шүүх бөгөөд 2 тойрог болгон, эрүү, иргэний хэргийн дагнасан тогтолцоог хэвээр хадгална.

Харин нийслэлийн Налайх, Багануур, Багахангай дүүргийн дагнасан эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, иргэний хэргийн анхан шатны шүүхийг нэгтгэн зохион байгуулж, эдгээр дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүхийг 1 шүүх болгоно.

Ингэснээр одоо байгаа дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны 18 шүүхийг 5 шүүх болгон өөрчлөн байгуулна.

#### *2.2.Захиргааны хэргийн анхан шатны шүүх:*

Аймаг, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны нийт 22 шүүхийг шийдвэрлэсэн хэргийн тоо, ажлын ачаалал илт бага зэргийг харгалзан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар нэгтгэн зохион байгуулж, 11 шүүх болгон өөрчлөн байгуулна.

#### *2.3.Сум дундын анхан шатны шүүх:*

Одоогийн байгаа аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны 21 шүүх, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны 21, нийт 42 шүүхийг зохион байгуулалтын хувьд нэгтгэн сум дундын анхан шатны 21 шүүх болгон өөрчлөн байгуулна. Ингэснээр эдгээр аймаг дахь сум дундын анхан шатны 21 шүүх нь тухайн шүүхийн ачааллыг харгалзан, дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан,

танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын шүүхийн тухай хуулиар нээлттэй байна.

Харин одоо байгаа сум дахь сум дундын 8 шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг хэвээр үлдээнэ.

Дээрх аймаг болон сум дахь сум дундын анхан шатны шүүхүүд нь улсын хэмжээн дэх сум дундын анхан шатны шүүх тул нэршлийг улсын хэмжээнд нэгдсэн дугаарт оруулан нэрлэж жигдлэх нь оновчтой гэж үзэн өөрчилж, сум дундын анхан шатны 29 шүүхтэй байхаар байгуулна.

*2.4. Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх:*

Мөрдөн шалгах ажиллагаан дахь шүүхийн хяналтыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай процессоор хэрэгждэг тодорхой ажиллагаануудыг болон бага үнийн дүнтэй иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх хялбар ажиллагааны төрлөөр дагнасан шүүхийг ерөнхий харьяаллын шүүхээс тусад нь байгуулж, ингэхдээ нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд 1 шүүх байхаар тусгана.

Энэ төрлийн шүүх байгуулснаар дүүргийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачаалал 30-40 хувь багасаж зохист хэмжээнд очно гэж үзсэн болно.

Ингэснээр одоо байгаа анхан болон давж заалдах шатны нийт 116 шүүхийг 59 шүүхээр цөөрүүлж нийт 57 шүүхтэй болно.

3. Хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

**Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтолцоо боловсронгуй болсноор хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хугацаа бодитойгоор багасаж, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх, шүүхийн хараат бус байдал хангагдах, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвших суурь нөхцөл бүрдэх бөгөөд ингэснээр шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд учирч байгаа цаг хугацаа, эдийн засгийн зардал буурч, шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг шинэчилснээр эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.

2. Анхан шатны шүүхийг засаг захиргааны нэгжид байгуулснаар шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх нөхцөл сайжирна.

3. Анхан болон давж заалдах шатны шүүх орон нутагт нэг байранд шүүн таслах ажиллагааг явуулдаг, дээд шатны шүүхээс шүүх бүрэлдэхүүн томилдог байдлыг

халж, шүүх, шүүгчийн хараат бус байдал дээшлэн шүүхэд хандах иргэний эрхийн баталгаа, шударга шүүхээр шүүлгэх, хуулийн өмнө эрх тэгш байх зарчим бодитоор хэрэгжинэ.

4.Хялбар ажиллагааны шүүхийг байгуулснаар мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналт, анхан шатны шүүхэд хэрэг хянагдах явцад процессын ноцтой зөрчил гардаг алдааг засуулахаар хэргийг дээд шатны шүүхээс буцаадаг ужгирсан асуудлыг шийдвэрлэх, хүний эрхийг хангах, бага үнийн дүнтэй иргэний хэргийг шийдвэрлэх хугацаа богиносж, улмаар иргэдэд үзүүлэх шүүхийн үйлчилгээний шуурхай байдал дээшилнэ.

5.Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдаж, шүүхийн шийдвэрийн чанар сайжирч, томилолтын зардал хэмнэгдэнэ.

6.Шүүгчийн орон тоог төлөвлөхдөө Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан “Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.” гэсэн зарчимд нийцүүлнэ.

7.Шүүх, шүүгчийн ачаалал тэнцвэржинэ.

8.Шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байн нөхцөл арилна.

9.Шүүхийн төсвийн хуваарилалт оновчтой болох нөхцөл бүрдэнэ.

Шүүхийн тогтолцооны шинэтгэлийг дагаад шүүхийн барилга, дэд бүтэц, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны эдийн засгийн баталгааг хангах болон тэдгээрийг шүүх хооронд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардлууд гарах бөгөөд үүнийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан “Зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу тооцно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийн төсөлтэй холбогдуулан гарах бусад хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, багцаар нь өргөн мэдүүлэх бөгөөд Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай болон “Шүүхийн барилга байгууламжтай холбоотой төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх болон холбогдох бусад авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---oOo---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

**Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар:**

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, үзэл баримтлалд тусгасан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн санал зэргийг үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан шаардлага, шалгууруудыг харгалзан Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал, байрших газар, зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатны шүүх байгуулахад оршино.

Хуулийн төсөлд анхан болон давж заалдах шатны шүүхийг байгуулах дараах зарчмын өөрчлөлтийг тусгав. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар өөрчлөн байгуулж, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн дагнасан тогтолцоог хэвээр хадгалан, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тусгав.

Ингэснээр хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүх байгуулах тухай хуулиар байгуулсан давж заалдах шатны 26 шүүхийг 13 шүүх болгон өөрчлөн байгуулахаар тусгалаа.

2. Нийслэлийн төвийн 6 дүүргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар зохион байгуулж, иргэний хэргийн 2, эрүүгийн хэргийн 2 буюу нийт 4 тойрог болгон, эрүү, иргэний хэргийн дагнасан тогтолцоог хэвээр хадгалж, харин нийслэлийн Налайх, Багануур, Багахангай дүүргийн дагнасан эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, иргэний хэргийн анхан шатны шүүхийг өөрчлөн зохион байгуулж, Эрүү, Иргэний хэргийн анхан шатны 1 шүүх болгон нэгтгэн өөрчлөхөөр, дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны нийслэлийн хэмжээнд 1 байхаар тусгав.

3. Аймаг, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны нийт 22 шүүхийг аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо, ажлын ачаалал илт бага зэргийг харгалзан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар нэгтгэн зохион байгуулж, 11 шүүх болгон байгуулах өөрчлөлтийг тусгалаа.

4. Одоо байгаа 21 аймаг дахь сум дундын анхан шатны иргэний хэргийн анхан шатны 21, эрүүгийн хэргийн анхан шатны 21, нийт 42 шүүхүүдийг зохион байгуулалтын



хувьд нэгтгэж, шүүхийн ажил үүргийн хуваарь, орон тоог оновчтой тогтоох зорилгоор сум дундын анхан шатны 21 шүүх болгон өөрчлөн байгуулахаар тусгав. Ингэснээр 21 аймаг дахь сум дундын анхан шатны 21 шүүх нь тухайн шүүгчийн ачааллыг харгалзан, дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан, танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын шүүхийн тухай хуулиар нээлттэй болно.

Харин одоо байгаа сум дахь сум дундын 8 шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг хэвээр үлдээв.

**Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

#### *1993 оны Шүүх байгуулах тухай хууль*

1992 онд ардчилсан Монгол Улсын Үндсэн хуулийг баталж, түүнд нийцүүлж холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд 1993 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүхийн тогтолцоог өөрчлөн, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг бий болгож, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх үндэс суурийг тавьсан бөгөөд 1993 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Шүүх байгуулах тухай хуулийг баталсан.

Энэхүү 1993 оны Шүүх байгуулах тухай хуулиар Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан шүүхийн тогтолцооны дагуу сумын шүүх 1, сум дундын шүүх 26, дүүргийн шүүх 8 байхаар хуульчилж, дүүргийн шүүхийг 1-8 хүртэл дугаарлаж нэрлэсэн. Харин давж заалдах шатны шүүхийг “аймаг, нийслэлийн шүүх” болгон өөрчилж, аймгийн шүүх 21, нийслэлийн шүүх 1 байхаар хуульчилж байжээ.

Дээрх хууль 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хэрэгжсэн.

#### *Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль*

Түүнчлэн Улсын Их Хурлаас 1998 онд баталсан “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх зорилгоор Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталж, Монгол Улс захиргааны хэргийн дагнасан шүүхтэй болсон бөгөөд 21 аймаг бүрд аймгийн захиргааны хэргийн шүүх, Улаанбаатар хотод Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, нийт 22 захиргааны хэргийн шүүхийг байгуулсан байна. Улмаар 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хуулийг баталж, “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх” нэртэйгээр байгуулан, Улаанбаатар хотод байршихаар тусгаж, нутаг дэвсгэрийн харьяаллын хувьд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалуулсан. Улсын дээд шүүхийг оруулаад нийт 84 шүүх байгуулж байсан байна.

#### *2013 оны Шүүх байгуулах тухай хууль*

Шүүх эрх мэдлийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлэх үүднээс Шүүхийн тухай багц хууль болох 6 хуулийг 2012 онд баталсан. Үүнийг дагаад Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2013 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан.

Уг хуулийн дагуу Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 4, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4, Захиргааны хэргийн анхан шатны шүүх 20, сум дундын шүүх 29-ийг байгуулж байсан.

Харин аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, нутаг дэвсгэрийн ойр дөт байдал, шүүхийн ачааллыг харгалзан тус бүр 2-3 аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг харьяалсан эрүүгийн болон иргэний хэргийн давж заалдах шатны шүүх тус бүр 10, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 1, нийт 21 давж заалдах шатны шүүх байгуулсан. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхээс бусад шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаараа онцлог байсан байна. Нийт 79 шүүх байгуулж байсан байна.

Дээрх Шүүх байгуулах тухай хуулиудаар шүүхийг тойргийн зарчмаар байгуулсантай холбоотой маргаан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан.

### *2015 оны Шүүх байгуулах тухай хууль*

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахаар шинэчлэн найруулсан 2013 оны Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болж, улмаар 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хуулиар 2013 оны Шүүх байгуулах тухай хуулиар шүүхүүдийг дэс дугаараар нэрлэж байсныг өөрчлөн, давж заалдах шатны шүүхүүдийг аймгийн нэрээр, дүүргийн шүүхүүдийг дүүргийн нэрээр нь тус бүр тоочин нэрлэсэн. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн “Дүүрэг бүр, аймаг бүр шүүхтэй байх ёстой гэсэн” тайлбарыг тойрч гарах оролдлого байсан байна. Учир нь шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан нь нэгдүгээрт шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлсэн, хоёрдугаарт дүүргийн шүүх болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнуулан байгуулах нөхцөлийг бүрдүүлж байсантай холбоотой байсан байна.

Дээрх 2015 оны Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалт буюу 1 дүгээр зүйлээр иргэний болон эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийг, 2 дугаар зүйлээр дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх байгуулахдаа нэрийн хувьд “аймгийн” болон “дүүргийн” гэж томьёолсон боловч энэ нь 2-3 аймгийн дунд давж заалдах шатны шүүх 1, 2-3 дүүргийн дунд анхан шатны шүүх 1 байх агуулгыг илэрхийлж байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд бэхжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмаар зохион байгуулагдах Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог үгүйсгэж зөрчсөн байна” гэж үндэслэн Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтуудыг түдгэлзүүлсэн бөгөөд энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн.

### *2016 оны Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль*

2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулсан бөгөөд уг өөрчлөлтөөр давж заалдах болон дүүргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан зохион байгуулалтыг халж, аймаг бүрд давж заалдах шатны шүүх, дүүрэг болгонд анхан шатны шүүх байхаар хуульчилсан. Мөн Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт давж заалдах шатны шүүх болон анхан

шатны шүүхүүдийг дагнасан хэлбэрээр байгуулахаар зохицуулснаараа 1993 оны Шүүх байгуулах тухай хуулиас ялгаатай юм. Түүнчлэн анхан шатны шүүхийг иргэний болон эрүүгийн хэргээр нь дагнасан хэлбэрээр зохион байгуулснаараа шүүхийн тоо нэмэгдсэн. Улсын дээд шүүхийг оруулаад нийт 117 шүүхтэй болсон.

Шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулах нь шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөр мэргэших, ингэснээр шүүхийн үйл ажиллагааны үр нөлөө дээшлэх, хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, шүүхийн шийдвэрийн чанар сайжрах зэрэг олон давуу талтай ч, нөгөө талаас шүүхийнтоо нэмэгдсэнээр төсөв, дэд бүтэц, байр байшингийн хүрэлцээний асуудал, шүүгчийн ачаалал харилцан адилгүй зэрэг сөрөг үр дагавартай байдаг. Иймд шүүн таслах ажиллагааны төрлөөр мэргэшүүлэн дагнуулах асуудлыг танхимын зохион байгуулалтаар шийдвэрлэх нь хамгийн үр дүнтэй хэлбэр гэж олон улсад үздэг байна.

### **Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

-Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1650, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1123, 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/1156, 08 дугаар сарын 21-ний өдрийн 03/1467 тоот албан бичгүүдээр ирүүлсэн саналыг харгалзан хууль санаачлагчийн хувьд үзэл баримтлалд дурдсан бодлоготой уялдуулан хуулийн төслийг боловсруулав.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/140 дүгээр тушаалаар Шүүх байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан.

-Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулахад анхаарах асуудлын талаар санал солилцов.

-Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуульд заасан судалгааг хийж байгааг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулсан Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 566,294,322.0 төгрөгний зардал гарах тооцоо хийгдсэн бөгөөд тус яамнаас боловсруулсан хуулийн төсөлд гарах зардлын тооцоог аргачлалын дагуу хийж байна. Түүнчлэн шүүхийн барилга байгууламжтай холбоотой төслийг төр хувийн хэвшлэлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлын тогтоол боловсруулна.

-Хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулав.

### **Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

Тус яамнаас боловсруулсан хувилбарт одоогийн байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөл анхан болон давж заалдах шатны шүүхээс санал авахад давж заалдах шатны нийт 26 шүүхийн 64% нь давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахыг дэмжсэн байна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, цахим хуудсандаа байршуулж санал авах зэрэг хэлбэрүүдээр олон нийтээр хэлэлцүүлэх ажиллагааг хийж байна. Эдгээр ажиллагааг хийж дууссаны дараа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө хэлэлцүүлгийн үр дүнг энд тодорхой тусгах болно.

### **Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлтийн талаар:**

-Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 58 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн судалгаа, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллын ажлын байрны судалгаа, Шүүгчийн ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох, баталгаажуулах судалгаа 2022 он:

-Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр Хууль эрх зүйн хөгжлийн газраас хийсэн “Шүүхийн тогтолцоо:Тойргийн болон дагнасан шүүх” бодлогын судалгаа 2021 он.

---oO---

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

### ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГЫН ТАЛААР:

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”, “2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг хууль болон бодлогын баримт бичигт “шүүхийг тойргийн зарчмаар байгуулах, ингэхдээ иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлэх чиглэлийг баримтлан Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулах”-ыг Засгийн газарт даалгасан.

Монгол улсын шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхтэй зөвшилцөж Шүүх байгуулах тухай хуулийн төслийн саналыг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1123 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд хуулийн төслийг боловсруулахдаа үүнийг харгалзав.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан практик хэрэгцээ, шаардлагад <sup>1</sup> тулгуурлан хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн шүүх байгуулах асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон хөндлөнгийн байгууллагатай хамтран судалгаа <sup>2</sup> хийж уг судалгаа нь шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик, шүүхийн захиргааны тайлан, мэдээлэл болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд хийсэн ажлын байрны ажиглалт, асуумж, хэрэг уншилтын тоо, мэдээнд тус тус үндэслэсэн байх бөгөөд судалгааны гол үр дүнг багцлан дүгнэхэд одоогийн шүүхийн зохион байгуулалтад тулгарч буй цаашид шийдвэрлэх шаардлагатай дараах хүндрэл бэрхшээл байгааг харуулсан байна.

---

<sup>1</sup> Шүүхийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал ын 2-4 дэх хуудас

<sup>2</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1123 тоот албан бичгээр ирүүлсэн танилцуулга

-Улсын хэмжээнд хүлээн авсан нийт иргэний хэргийн 65%, эрүү, захиргааны хэргийн 60 орчим хувийг нийслэл дэх дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна. Улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн 52.3%, иргэний хэргийн 55.5%, захиргааны хэргийн 58.6 хувийг нийслэл дэх дүүргийн анхан шатны шүүхүүд хянан шийдвэрлэсэн дүнтэй байна.

-Анхан шатны шүүхээр сүүлийн 5 жилд хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн 18.8%, иргэний хэргийн 6.9%, захиргааны хэргийн 43.2 хувийг давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 22.8%, иргэний хэргийн 44.1%, захиргааны хэргийн 56% нь хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн байна.

-2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хугацаанд давж заалдах шатны шүүхүүд нийтдээ 26075 хэргийн оролцогч бүхий 8876 шүүх хуралдаан хийсний 5191 шүүх хуралдаан буюу 58.4%-ийг цахимаар явуулсан байна. Шүүх хуралдаанд оролцогчдын 48.37% нь биечлэн оролцжээ.

-Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд 91 эрүүгийн хэрэг, 731 зөрчлийн хэрэг, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд 209 хэрэг, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд 35 хэрэг, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч жилд 49 эрүүгийн хэрэг, 110 зөрчлийн хэрэг, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч жилд 126 хэрэг, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч жилд 31 хэрэг хянан шийдвэрлэж байна.

-Төвийн 6 дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал 50%, зөрчлийн хэргийн шүүгчийн ачаалал 150%, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 80%, орон нутаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн ачаалал 8.6 цаг буюу 10 %-иар, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 81%-иар, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ачаалал 10 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын хэмжээнээс 25%-иар, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ачаалал 10%-иар тус тус хэтэрсэн байна.

-Захын дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 4.6 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 58.8%-д хүрэх хэмжээний ачаалалтай, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 6.2 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 77%-д хүрэх хэмжээний ачаалалтай ажиллаж байгаа ба аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид мөн зохист ачаалалд хүрэхгүй хэмжээнд ажиллаж байна.

-Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 55%-иар, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ачаалал 99%-иар хэтэрсэн байгаа бол орон нутаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 3 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 37.5%-д хүрэх хэмжээний ачаалал авч, 62.5%-ийн ачаалал дутуу ажилладаг байна.

-Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан шинэ хуулиудын хэрэгжилт шүүхийн үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлж байна. Тухайлбал, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай

хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжсэн нь шүүхэд эрүүгийн хэргийн шүүхээр эрхээ хамгаалуулах үйл ажиллагаа 2.2 дахин нэмэгдэхэд хүргэсэн байна.

-2020-2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 35.3% -ийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн дүн мэдээтэй байна.

-Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017- 2021 оны дунджаар хүлээн авсан нэхэмжлэлийн 46.7%-ийг бага үнийн дүнтэй нэхэмжлэл эзэлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахаар тусгасныг давж заалдах шатны нийт 26 шүүхийн 64% нь дэмжсэн байна.

### **ХУУЛИЙН ТӨСЛӨӨР ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦААНЫ АГУУЛГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал, байрших газар, зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатны шүүх байгуулахад оршино.

Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, төвлөрлийг сааруулах, шүүхийн хөрөнгө оруулалт, барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх бодлого зэрэгтэй уялдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо, иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг дордуулахгүй байх, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх зарчмыг баримталлаа.

Олон улсын түвшинд шүүхийн үйлчилгээний хүртээмжийг засаг захиргааны нэгж бүрд шүүх байршуулснаар бус харин шүүгчийн орон тооны хүрэлцээтэй байдал, иргэний шүүхэд хандах эрхийг хангах эрх зүйн орчин, шүүхийн үйлчилгээний мэдээллийг иргэдэд хүргэх үр өгөөжтэй механизм, иргэдийн төрөөс эрх зүйн туслалцаа авах боломж, шүүхийн өмнөх маргаан шийдвэрлэх ажиллагааг бүрдүүлсэн байдал, цахим технологийн дэвшлийг ашиглан иргэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран шүүхэд хандах боломжийг бүрдүүлсэн байдлаар ойлгож байгааг харгалзав.

Түүнчлэн дэлхийн ихэнх оронд дагнасан шүүх гэх ойлголтыг шүүхийг дагнан байгуулах, танхимын зохион байгуулалтаар байгуулах, дагнасан буюу мэргэшсэн шүүгчийг томилох гэх загварт хуваан авч үзэж байгаа бөгөөд дагнасан хэлбэрээр танхим байгуулах асуудлыг шүүхийн захиргаа, хүний нөөц, төсвийн хувьд хэмнэлттэй, шүүхийн тогтолцооны хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг байна. Иймд шүүх бүтэц, зохион байгуулалтын хувьд нэг шүүхийн зохион байгуулалтад орох нь дагнасан шүүхийн тогтолцооноос ухарч буй хэлбэр биш бөгөөд ийнхүү эрүү, иргэний хэргийн зэрэг танхимын зохион байгуулалтад оруулж, танхимын бүрэлдэхүүн өөр

өөрсдийн харьяалах танхимын хэрэг маргааныг шийдэх нь мөн л ялгаагүй шүүгчийг дагнан мэргэшүүлэх нэг хэлбэр гэдгийг мөн харгалзан үзлээ.

Дээрх шаардлага, шалгууруудыг харгалзан Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд давж заалдах болон анхан шатны шүүхийг дараах байдлаар байгуулахаар тусгалаа. Үүнд:

### **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл: Давж заалдах шатны шүүх байгуулах талаар**

Аймаг, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар өөрчлөн байгуулж, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн дагнасан тогтолцоог хэвээр хадгалан, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тусгав.

Давж заалдах шатны шүүхийн тухайд хэргийн оролцогч давж заалдах гомдлыг анхан шатны шүүхээр дамжуулан гаргадаг, давж заалдах шатны шүүх хуралдааныг хэргийн оролцогчийг заавал байлцуулахгүйгээр шийдвэрлэдэг процесс хуулийн зохицуулалт, давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй нотлох баримтыг хэлэлцдэггүй, хэргийг хавтаст хэрэг цугласан баримтын хүрээнд хянадаг, улсын хэмжээнд нийт эрүүгийн хэргийн 18 орчим хувь, иргэний хэргийн 6 орчим хувь нь давж заалдсан сүүлийн 5 жилийн статистик тоо, давж заалдах шатны шүүх хуралдааны 50 орчим хувийг цахим шүүх хуралдаан эзэлж байгаа судалгааны дүн, нийслэл дэх болон орон нутаг дахь давж заалдах шатны шүүхийн ачааллын эрс ялгаатай байдал, шүүх бүрэлдэхүүний хүрэлцээ зэргийг харгалзлаа.

Монгол Улсын хэмжээнд байгаа эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 25 шүүхийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар нэгтгэн зохион байгуулж, 12 шүүх болгон өөрчлөн байгуулахаар тусгалаа.

Ингэхдээ нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо, ачаалал зэргийг харгалзан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийг 2 аймгийн дунд 1 шүүх байхаар тойроглон тусгалаа. Эдгээр давж заалдах шатны шүүх дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан, танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын шүүхийн тухай хуулиар нээлттэй болно.

Харин 2017-2022 оны шүүн таслах ажиллагааны статистик тоон мэдээллээр улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 13542 хэргийг хянан шийдвэрлэснээс 7075 буюу нийт хэргийн 51.9%-ийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэсэн бол Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд 19301 хэргийг хянан шийдвэрлэснээс 13707 хэргийг буюу нийт хэргийн 71.1%-ийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх тус тус хянан шийдвэрлэсэн байгааг харгалзан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн дагнасан тогтолцоог хэвээр үлдээж, ингэхдээ эдгээр давж заалдах шатны шүүхийг



төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхтэй тойргийн зарчмаар нэгтгэн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны тойргийн шүүх, Иргэний хэргийн давж заалдах шатны тойргийн шүүх гэж дагнуулан 1 тойрог болгох өөрчлөлтийг тусгав.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тухайд дагнасан шүүхийн одоогийн тогтолцоог хэвээр хадгалав.

Ингэснээр хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүх байгуулах тухай хуулиар байгуулсан давж заалдах шатны 26 шүүхийг 13 шүүх болгон өөрчлөн байгууллаа.

### **Хуулийн төслийн 2 дугаар зүйл: Анхан шатны шүүх байгуулах талаар**

Анхан шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг дараах байдлаар тусгав.

#### *Дүүргийн анхан шатны шүүх:*

Нийслэл дэх хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн төвлөрөл, дэд бүтцийн хөгжил, нийтийн тээврийн хүрэлцээ болон төвийн дүүргийн шүүхүүд нь нэршлийн хувьд дүүрэг тус бүрд байгаа боловч байршлын хувьд 3 дүүргийн шүүх нь 1 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг, 1 байранд байрлаж байгаа, дүүргийн шүүхүүдийн шийдвэрлэсэн хэргийн тоо, ажлын ачааллыг харгалзан одоо байгаа дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 9, Эрүүгийн хэргийн анхан шатны 9, нийт 18 шүүхийн зохион байгуулалтыг өөрчлөн байгууллаа.

Ингэхдээ нийслэлийн төвийн 6 дүүргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар зохион байгуулж, иргэний хэргийн 2, эрүүгийн хэргийн 2 буюу нийт 4 шүүх бөгөөд 2 тойрог болгон, эрүү, иргэний хэргийн дагнасан тогтолцоог хэвээр хадгалав.

Харин нийслэлийн Налайх, Багануур, Багахангай дүүргийн дагнасан эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, иргэний хэргийн анхан шатны шүүхийг өөрчлөн зохион байгуулж, Эрүү, Иргэний хэргийн анхан шатны 1 шүүх болгон нэгтгэн тусгалаа.

Ингэснээр хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүх байгуулах тухай хуулиар байгуулсан дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны 18 шүүхийг 5 шүүх болгон тусгав.

#### *Захиргааны хэргийн анхан шатны шүүх:*

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тухайд нийслэлээс бусад 21 аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал илт бага байгаа талаар судалгаа гарсан байна.<sup>3</sup> Уг судалгаанд “2020 оны байдлаар Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд захиргааны 52.5 хэрэг хянан шийдвэрлэсэн байхад бүх аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

---

<sup>3</sup> Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгээс хийсэн “Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх” бодлогын судалгаа

дунджаар 11.2 хэрэг шийдвэрлэсэн нь даруй тав дахин бага ачаалалтай байгаа нь ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна. Нийслэлээс бусад орон нутаг дахь бүх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн жилд шийдвэрлэж буй хэргийн тоо байвал зохих хэмжээний 22 хувьд л хүрч байна. Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгууд дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчид ногдох хэрэг дунджаар 10 хүрэхгүй байгаа нь байвал зохих ачааллаас 80 орчим хувиар бага байна.” гэж дүгнэсэн байдаг.

Түүнчлэн аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны бүх шүүхийн шийдвэрлэсэн хэргийн 2020-2022 оны байдлаарх тоон статистикаас<sup>4</sup> харахад хэргийн тоо зарим аймагт өссөн үзүүлэлттэй байх хэдий ч жилд 1 шүүгчид ногдох зохих ачаалалд хүрэхээргүй байна.

Аймаг, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны нийт 22 шүүхийг аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо, ажлын ачаалал илт бага зэргийг харгалзан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар нэгтгэн зохион байгуулж, 11 шүүх болгон байгуулах өөрчлөлтийг тусгав.

Ийнхүү Захиргааны хэргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар ажлын ачааллыг тэнцвэржүүлж, шүүгчийн орон тоо сулрахаар байх ба эдгээр орон тоог ажлын ачаалал өндөртэй бусад шүүхэд шилжүүлэх боломжтой гэж үзсэн болно.

#### *Сум дундын анхан шатны шүүх:*

Аймаг дахь сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн тухайд одоо үйлчилж байгаа тогтолцоогоор засаг захиргааны үндсэн нэгжид анхан шатны шүүхүүдийг байгуулснаар иргэнд ногдох шүүхийн хүртээмж хэвийн байгаа хэдий ч эрүү, иргэний хэргийн шүүхүүдийг дагнаж байгуулсан нь шүүхийн нөөцийг сарниаж, анхан шатны зарим шүүхүүд 1-2 шүүгчтэй ажиллаж байгаа нь иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, шүүхийн төсөв, шүүгчдийн хараат бус болон аюулгүй, бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна.

Шүүгчийг татгалзах, хэргийг шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг санамсаргүй сонгох, хэргийг шийдвэрлэх шүүгч давхцахгүй байх зэрэг иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх хэрэгжих баталгаа болсон зарчмууд биелэхэд орон нутаг дахь анхан шатны шүүхийн тогтолцоо хүндрэл учруулж байна.

Адил шатны шүүхээс сум, заримдаа аймаг алгасан шүүх бүрэлдэхүүнийг томилуулж байгаа нь шүүхийн төсөв, шүүгчийн аюулгүй байдалд эрсдэл, хохирол учруулсаар байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан одоо байгаа 21 аймаг дахь сум дундын анхан шатны иргэний хэргийн анхан шатны 21, эрүүгийн хэргийн анхан

---

<sup>4</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон статистик мэдээлэл

шатны 21, нийт 42 шүүхүүдийг зохион байгуулалтын хувьд нэгтгэж, шүүхийн ажил үүргийн хуваарь, орон тоог оновчтой тогтоох зорилгоор сум дундын анхан шатны 21 шүүх болгон өөрчлөн байгуулахаар тусгав.

Ингэснээр 21 аймаг дахь сум дундын анхан шатны 21 шүүх нь тухайн шүүгчийн ачааллыг харгалзан, дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан, танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын шүүхийн тухай хуулиар нээлттэй байна.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн төслийн саналд тусгасан “Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” байгуулах асуудлыг заавал шүүх байгуулах замаар бус дээрх танхимын зохион байгуулалтын замаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно.

Харин одоо байгаа сум дахь сум дундын 8 шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг хэвээр үлдээв.

Дээрх сум дундын анхан шатны шүүхүүд нь улсын хэмжээн дэх сум дундын анхан шатны шүүх тул нэршлийг улсын хэмжээнд нэгдсэн дугаарт оруулан нэрлэж жигдлэх нь оновчтой гэж үзэн өөрчилж, сум дундын анхан шатны 29 шүүхтэй байхаар байгуулна.

*Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх:*

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл болон Нэгдсэн Үндэсний байгууллагын Дур зоргоор баривчлан саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлтэд сэжигтнийг баривчлах ажиллагаа шүүхийн зөвшөөрөлгүй явагддаг, шүүхийн хяналтад бүрэн ороогүй байгаатай холбогдуулан сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг нэг мөр хэрэгжүүлэх байдлаар шүүхийн хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байгаа талаар дурджээ. Энэ асуудалтай холбогдуулан хууль сахиулах байгууллагаас шүүхийн байгууллагад хандан ажлын цаг дууссаны дараа, амралтын болон бүх нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд баривчлах ажиллагаа хийгддэгтэй холбогдуулан 24 цагийн шүүх, жижүүрийн шүүх ажиллуулах хэрэгцээ шаардлага байгаа талаар санал, хүсэлт их гарсаар байна.

Түүнчлэн сүүлийн 3 жилийн шүүн таслах жаиллагааны статистик дүн мэдээгээс үзэхэд 2020-2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 35.3 хувийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн нийт 14016 хэргийн 49.6 хувь буюу 6949 хэргийг нийслэлд, 50.4 хувь буюу 7067 хэргийг орон нутагт тус тус хянан шийдвэрлэжээ.

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017-2021 онд дунджаар хүлээн авсан нэхэмжлэлийн 46.7 хувийг бага үнэ /10 саяаас хэтрэхгүй/-ийн дүнтэй

нэхэмжлэл эзэлсэн байна. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчийн хүлээн авсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо дүүрэг бүрд харилцан адилгүй байгаа боловч жилд дунджаар 136 нэхэмжлэл хүлээн авсныг зохист ачаалал гэж судалгаагаар дүгнэжээ. Мөн судалгаагаар хийсэн өгөгдөлд үндэслэн нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах, энэ төрлийн нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гарагх нь нийт хэргийг шийдвэрлэх ачааллаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгоно гэж дүгнэсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан мөрдөн шалгах ажиллагаан дахь шүүхийн хяналтыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай процессоор хэрэгждэг тодорхой ажиллагаануудыг болон бага үнийн дүнтэй иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх хялбар ажиллагааны төрлөөр дагнасан шүүхийг ерөнхий харьяаллын шүүхээс тусад нь байгуулж, ингэхдээ нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд 1 шүүх байхаар тусгалаа

Энэ төрлийн шүүх байгуулснаар дүүргийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачаалал 30-40 хувь багасаж зохист хэмжээнд очно гэж үзсэн болно.

Ингэснээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүх байгуулах тухай хуулийн дагуу байгуулсан анхан болон давж заалдах шатны нийт 116 шүүхийг 59 шүүхээр цөөрүүлж нийт 57 шүүхтэй байхаар тусгалаа.

### **Хуулийн төслийн 3 дугаар зүйл:Хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар**

Хууль хэрэгжих боломжит хугацаанаас хамаарч хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

### **ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН НЭР ТОМЬЁОНЫ ТАЛААР:**

Хуулийн төсөлд одоо байгаа Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийг тойргийн зарчмаар нэгтгэн байгуулж байгаатай холбогдуулан тухайн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх харьяалалд хамаарах бүх аймгийн нэрийг нэг бүрчлэн дурдаж, “Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны ... дүгээр/дугаар тойргийн шүүх” гэж нэрлэхээр тусгав.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тухайд улсын хэмжээнд нэг хэвээр байх тул харьяалал болон нэршлийг мөн хэвээр үлдээсэн.

Дүүргийн анхан шатны шүүхийн тухайд дагнасан байдлыг хадгалан тойрогт хуваан байгуулж байгаатай холбогдуулан тухайн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх харьяалалд хамаарах дүүргийн нэрийг нэг бүрчлэн дурдаж, “Дүүргийн иргэний/эрүүгийн хэргийн анхан шатны ... тойргийн шүүх” гэж нэрлэх, харин нийслэлийн Налайх, Баганхангай, Багануур дүүргийн дагнасан эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, иргэний хэргийн анхан шатны шүүхийг нэгтгэн 1 шүүх байгуулж

байгаатай холбогдуулан “Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж нэрлэхээр тусгалаа.

Нэгтгэн байгуулж байгаа аймаг дахь сум дундын анхан шатны 21 шүүх болон хэвээр үлдээж буй сум дахь сум дундын 8 анхан шатны нийт 29 шүүх нь улсын хэмжээн дэх сум дундын анхан шатны шүүх тул тухайн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх харьяалалд хамаарах аймаг, сумын нэрийг нэг бүрчлэн дурдаж, нэршлийг улсын хэмжээнд нэгдсэн дугаарт оруулан “Сум дундын анхан шатны ... дүгээр/дугаар шүүх” нэрлэж жигдлэх нь оновчтой гэж үзсэн болно.

Ийнхүү анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтолцоо боловсронгуй болсноор хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хугацаа бодитойгоор багасаж, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх, шүүхийн хараат бус байдал хангагдах, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвших суурь нөхцөл бүрдэх бөгөөд ингэснээр шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд учирч байгаа цаг хугацаа, эдийн засгийн зардал буурч, шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ гэж үзэж байна.

---oOo---

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болмогц анхан болон давж заалдах шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааныг Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ

**2 дугаар зүйл.** Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай холбогдуулан шүүгчийг анхан болон давж заалдах шатны шүүхэд шилжүүлэн томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 20... оны .... дүгээр/дугаар сарын ...-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Шүүхийн ерөнхий зөвлөл /Р.Онончимэг/-д даалгасугай:

1/Монгол Улсын шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангахад шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлэх;

2/иргэнд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, зориулалтын шаардлага хангасан барилга байгууламж шинээр барихтай холбоотой төслийг төр, хувийн хэвшлэлийн түншлэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

2.Монгол Улсын шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан байгууллагуудад тус тус зөвлөсүгэй:

1/Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Арилжааны танхим байгуулах асуудлыг авч хэрэгжүүлэхийг Улсын дээд шүүх /Д.Ганзориг/-т;

2/Шүүгчийн орон тооны хязгаарын саналыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд өргөн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /Р.Онончимэг/-д;

3/Прокурорын байгууллагын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай уялдуулан өөрчлөх тухай саналыг .....-ны өдрийн дотор Улсын Их Хуралд ирүүлэхийг Улсын ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/-т;

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Б.Энхбаярт/-нд даалгасугай.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллагын оршин байгаа газрын” гэснийг “өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дүгээр  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай 9 дүгээр зүйлийн доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхэд ажиллаж байгаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй шүүгчийн туслах Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 89.1-д заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд хангана. Энэ хугацаанд ажиллаж байгаа шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй бол мэргэжлийн дадлага хийсэнд тооцож хуульчийн сонгон шалгаруулалтад оролцох боломжоор хангана.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт нэмсүгэй.

“11.1.5.шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн мэдээллэл, лавлагааны мэргэжилтэн.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг